

## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны ... дугаар  
сарын ... -ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

### Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал"-ын 4.5 дугаар зүйл, "Мандал голомт" ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 195 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын "Мандал Голомт" ХХК-ийн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг "Мандал голомт" ХХК (С.Дарамдад)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 498, 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 27, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 187 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны  
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД  
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ**

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын “Мандал Голомт” ХХК-ийн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно. Үүнд:

| № | Хэрэглэгчийн ангилал |                                       | Хэмжих нэгж | Тариф /НӨАТ-гүй/ |          |
|---|----------------------|---------------------------------------|-------------|------------------|----------|
| 1 | Төсөвт байгууллага   | Эзлэхүүнээр халаалт                   |             | Төг/м³           | 2,994.0  |
|   |                      | Хэмжүүрээр халаалт                    | хувьсах     | Төг/ГЖ           | 50,400.0 |
|   |                      |                                       | тогтмол     | Төг/м³           | 1,677.0  |
|   |                      | Хэрэгцээний халуун ус халаасан дулаан |             | Төг/м³           | 3,000.0  |

Эрчим хүчний зохицуулах хорооны  
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН  
НЭГЖ, БАЙГУУЛЛАГА БОЛОН АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ  
ДУЛААНЫ ТАРИФ**

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын “Мандал Голомт” ХХК-ийн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно. Үүнд:

| № | Хэрэглэгчийн ангилал                                                         |                                           | Хэмжих нэгж | Тариф /НӨАТ-гүй/ |          |
|---|------------------------------------------------------------------------------|-------------------------------------------|-------------|------------------|----------|
| 1 | Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага                                          | Эзлэхүүнээр халаалт                       |             | Төг/м³           | 2,604.0  |
|   |                                                                              | Хэмжүүрээр халаалт                        | хувьсах     | Төг/ГЖ           | 43,825.0 |
|   |                                                                              |                                           | тогтмол     | Төг/м³           | 1,458.0  |
|   |                                                                              | Хэрэгцээний халуун ус халаасан дулаан     |             | Төг/м³           | 3,000.0  |
| 2 | Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “00” –ын өрөөний халаалт хамаарна) |                                           | Төг/м²      | 1,400.0          |          |
| 3 | Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф                                      | 40 м² хүртэлх талбайтай айл өрх           |             | Төг/сар          | 5,000.0  |
|   |                                                                              | 41 м²-аас 80 м² хүртэлх талбайтай айл өрх |             | Төг/сар          | 8,000.0  |
|   |                                                                              | 81 м²-аас дээш талбайтай айл өрх          |             | Төг/сар          | 12,000.0 |

---oOo---